

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

ШС-ийн 2023 оны 11/30-р шүүмэл.

Дагаж мөрдөх огноо:

2023.10.02.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.10.02.

Байгууллагын нэр:

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Нэгжийн нэр:

Лавлагаа лабораторийн алба

Албан тушаалын нэр:

Нян судлагч эмч, Зоонозын өвчин судлалын эмч, чанарын менежер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ-6

Ажлын цаг:

6 цаг (08³⁰-15³⁰)

Ажлын байрны албан ёсны байршил:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн өөрийн байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн бус

Онцгой нөхцөл:

- Хортой

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Алба, тасаг нэгжийн чиг үүргийн хүрээнд лабораторийн тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу мэргэжлийн төвшинд үзүүлэх

Албан тушаалын зорилт:

1. Лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх
3. Сургалтад хамрагдах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, оролцох
4. Бусад

Албан тушаалын үндсэн хариуцлага:

1. Чанарын удирдлагын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалахад шаардлагатай үйл явцаар хангах
2. Лабораторийн бодлого, зорилт, нөөц болон чанарын удирдлагын тогтолцооны гүйцэтгэл, шаардлагатай сайжруулалтын асуудлаар шийдвэр гаргах түвшинд лабораторийн удирдлагад тайлагнах
3. Лабораторийн зохион байгуулалтын дагуу хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангах
4. Бруцеллёзын лаборатори, Сорьц хүлээлцэх лаборатори, Сорьц хадгалах лабораторийн бэлэн байдлыг хангах

Ажил гүйцэтгэхэд олгох эрх :

1. Тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр сургалтанд хамрагдаж өөрийгөө хөгжүүлэх
2. Тусламж үйлчилгээний чанар сайжруулан ажиллаж буй ажилтнуудад шагнал урамшуулал олгох талаар санал дэвшүүлэн шийдвэрлүүлэх
3. Байгууллагын тулгамдсан болон удаан хугацаанд шийдвэрлэхгүй байгаа асуудлын талаар санал боловсруулан удирдах ажилтанд танилцуулах
4. Тусламж үйлчилгээний чанартай холбоотой тоо, мэдээллийг шаардлагатай эх үүсвэрээс гаргуулан авах
5. Хийсэн ажлын үр дүнгээр урамшуулалд хамрагдах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	- Лабораторийн онош зүйн тусламж, үйлчилгээг стандарт, удирдамж, заавар, зөвлөмжийн дагуу гүйцэтгэх, хяналт тавих	- Лабораторийн онош зүйн тусламж үйлчилгээг стандарт, удирдамж, заавар, зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тоо, хянасан ажлын тоо	- Г, Х - Г, Х
	- Шинжилгээтэй холбоотой анхан шатны маягт, баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөх, хяналт тавих	- Анхан шатны бүртгэл маягт, баримт бичгийг зөв хөтлөх, бөглөсөн байх	-Г, Х
	- Халдвар хамгааллын дэглэм, лабораторийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах, хяналт тавих	- Халдвар хамгааллын дэглэм, лабораторийн аюулгүй ажиллагааны зөрчил гаргахгүй байх	-Г
	- Шаардлагатай нөхцөлд зөвлөх эмч болон бусад ижил мэргэжлийн эмч, мэргэжилтнээс зөвлөгөө авах, зөвлөгөөн хийх, асуудлыг шийдвэрлүүлэх	- Зөвлөгөө өгсөн тоо - Шийдвэрлэсэн ажлын тоо	
	- Шинжилгээний өмнөх, явцын болон дараах үе шатанд хяналт тавих	- Хяналт тавьсан ажлын тоо	-Г, Х
	- Лабораторийн шинжилгээний үр дүнг баталгаажуулах, мэдээлэх	- Батлагдсан удирдамж - Илтгэх хуудас - Үр дүнгийн тайлан	-Г

2 дугаар зорилтын хүрээнд	- Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр алба, тасгийн хүрээнд сургалт зохион байгуулах, оролцох	- Сургалтад хамрагдсан тоо	-Г, Т
	- Шаардлагатай тохиолдолд зоонозын халдварын тандалт, хариу арга хэмжээний чиглэлээр зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанд оролцох	- Зоонозын халдварын тандалт, хариу арга хэмжээний чиглэлээр оролцсон ажлын тоо, - Удирдамж, - Үр дүнгийн тайлан	-Г, Т
	- Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцох	- Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцсон тоо	-Г, Т
	- Шаардлагатай тохиолдолд орон нутагт ажиллах, төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх - Халдварт өвчний голомт, дэгдэлтэд халдвар эсэргүүцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, гамшгийн үед дайчлагдан ажиллах	- Батлагдсан ажлын удирдамж - Үр дүнгийн тайлан - Халдварт өвчний голомт, дэгдэлт, халдвар эсэргүүцэх арга хэмжээ, гамшгийн үед дайчлагдан ажилласан тоо - Ажлын удирдамж - Үр дүнгийн тайлан	-Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	- Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах	- Сургалтад хамрагдсан тоо	-Г, Т
	- Төгсөлтийн дараах сургалтын багц цагийн хөтөлбөрт хамрагдах	- Хөтөлбөрт хамрагдсан тоо - Багц цагийн биелэлт	-Г, Т
	- Эрдэм шинжилгээ, судалгааны болон халдварын багт ажиллах, онол практикийн хуралд илтгэл тавих	- Батлагдсан ажлын удирдамж - Үр дүнгийн тайлан - Илтгэл, өгүүллийн тоо	-Г, Т
	- Зоонозын халдварын оношлогоо, эмчилгээ, тандалтын стандарт, гарын авлага, аргачлал, мэргэжлийн ном туурвих, орчуулахад оролцох	- Стандарт, гарын авлага, арга аргачлал боловсруулсан тоо	-Г, Т

4 дүгээр зорилтын хүрээнд	- Орон нутгийн салбар лабораториудын эмч, лаборант нарт зориулсан сургалт удирдах, оролцох	- Зохион байгуулсан сургалтын тоо	-Г, Т
	- Мэргэшлийн чиглэлээр бусад салбарын эмч, мэргэжилтэнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох	- Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - Зохион байгуулсан сургалтын тоо - Мэдээ мэдээлэл солилцсон тоо	-Г, Т
	- Нян судлагч лаборант болон ижил мэргэжилтний ажиллагаанд хяналт тавих, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	- Хяналт тавьсан үйл ажиллагааны тоо - Хавсран ажилсан тоо	-Г, Т
	- Мэргэжлийн чиглэлээр ээлжлэн болон хавсран ажиллах	- нийтийн арга хэмжээнд оролцсон тоо	-Г, Т
	- Байгууллагаас зохион байгуулж буй соёл, олон нийтийн арга хэмжээнд оролцох	- Оролцсон ажлын тоо	-Г, Т
	- Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэхэд оролцох	- Сургалтад хамрагдсан тоо - Сургалтын тэмдэглэл	-Г, Т
	- Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- Батлагдсан ажлын удирдамж - Үр дүнгийн тайлан	-Г, Т
	- Өсгөвөр судалгаа хийх		-Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	- Чанар сайжруулах чиглэлээр тасгаас болон чанарын албанаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцох	- Оролцсон ажлын тоо	-Г, Т
	- Ажлын байрны эрсдэл үүсч болох нөхцөл байдлыг үнэлэн, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч хэрэгжүүлж байх	- Авч хэрэгжүүлсэн ажлын тоо	-Г, Т

Орлон хавсран ажиллах албан тушаал

Шаардлагатай тохиолдолд бусад нян судлагч эмчийг орлон ажиллана.

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн.
Мэргэжил	Хүний их эмч
Мэргэшил	- Үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан буюу мэргэжлийн дипломтой байх - Лабораторийн резидентийн сургалтад хамрагдсан буюу дипломтой байх - Зоонозын эмчийн олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдсан буюу мэргэжлийн үнэмлэхтэй байх
Туршлага	Нян судлагч эмчээр 5-аас доошгүй жил ажилласан байх
Ур чадвар	- Орчин үеийн лабораторийн орчинд, тоног төхөөрөмжтэй харьцах чадвартай байх - Ажлын эмх цэгцтэй, Анхаарлаа төвлөрүүлэх, дэс дараатай шаргуу ажиллах, нягт нямбай хичээнгүй зан чанартай байх - Хэвийн хурц хараа, гар хөдөлгөөний эвсэл дүй эзэмшсэн байх - Багаар ажиллах, бусдад зааж сургах чадвартай байх - Хариуцлага хүлээх, ажлын байранд хөрвөж ажиллах - Ярианы болон харилцаа, хувийн өндөр соёлтой, судлаачийн ёс зүйн чадвар эзэмшсэн байх - Ажлын цагийг сайтар баримталдаг, бусдадаа үлгэр жишээч байх - Шийдвэр гаргах чадвартай байх - Бусдад зөвлөгөө өгөх чадвартай байх - Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх - Эрүүл мэндийн болон холбогдох хууль, эрх зүйн мэдлэгтэй байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ


Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Лавлагаа лабораторийн албаны дарга У.Өнөрсайхан

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
- Лабораторийн бусад тусгай мэргэжилтэн - Бусад ажилтан	- Албаны дарга, их эмч, бусад ажилтан - Бусад алба, тасгийн дарга, бусад их эмч, мэргэжилтэн, тусгай мэргэжилтэн, бусад ажилтан - Орон нутгийн ЗӨСТөвийн эмч нар - Бусад төв эмнэлэг, тусгай мэргэжлийн эмнэлэг, бүсийн оношлогоо,

	эмчилгээний төвийн эмч нар - Тухайн мэргэжлийн нийгэмлэг, холбоод - Төрийн болон төрийн бус бусад байгууллага
--	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан		Албан тушаалын тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
ЗӨСҮТөвийн ерөнхий захирал Н. Цогбадрах  /гарын үсэг/ 2023 оны 10 сарын 02-ны өдөр	(Шууд удирдах албан хаагчийн дарга, эрхлэгчийн нэр, гарын үсэг) ЛЛА-ны дарга У.Өнөрсайхан  /гарын үсэг/ 2023 оны 10 сарын 02-ны өдөр	(Мэргэжилтэн, ажилтны нэр гарын үсэг) Нян судлагч, Зоонозын өвчин судлалын эмч, чанарын менежер Б.Байгальмаа  /гарын үсэг/ 2023 оны 10 сарын 02-ны өдөр